



“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Биржээр арилжигдсан барааны
тодорхойлолтын тухай

1. Биржээр арилжигдсан хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд, түүний гаалийн бүрдүүлэлт хийх чиглэлээр “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан хамтын ажиллагааны санамж бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Арилжааны хэлтэс /Т.Баасанжав/-т ТУШААХ НЬ:

1.1 Биржээр арилжигдсан боловсруулаагүй ноолуурын тодорхойлолтод ноолуурын хэмжээг самнасан болон угаасан ноолуурт шилжүүлэн хаалтанд давхар бичилт хийх.

1.2 Арилжааны зуучлагч /брокер/ компаниуд, тэдгээрийн харилцагчийн биржээр арилжсан бараанд олгосон болон хугацаа хэтэрсэн, хаяж үрэгдүүлсэн тодорхойлолтын талаарх мэдээллийг тухай бүр Улаанбаатар хот дахь Гаалийн газарт хүргүүлэх.

1.3 Биржээр арилжсан болон экспортонд гарсан хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн талаар цахим мэдээллийг харилцан солилцох.

2. Биржээс олгосон барааны тодорхойлолтыг улирал тутамд Улаанбаатар хот дахь Гаалийн газартай тулгаж, экспортын явцад гарч буй алдаа, зөрчлийг арилгаж ажиллахыг гүйцэтгэх захирлын зөвлөх бөгөөд ахлах аудитор /О.Сайнжаргал/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, дотоод аудитын хэлтсийн захирал /Т.Чинбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.БААТАР

0000000153